



ДУАГ

ДУНДГОВЬ АЯМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Дархлаажуулалтын сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайлан

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 100 дугаар тогтоол

ЗЭВЭЛ ХИЙХ ДАРХЛААЖУУЛААЛТЫН ҮНДЭСНИЙ ТОВАОЛ

Төрөл	Төрийн дархлаа сангийн дотроо	1 саягад	2 саягад	3 саягад	4 саягад	5 саягад	6 саягад	7 саягад	8 саягад	9 саягад	10 саягад
Бусадны нэр											
СҮРМЭЭ (52%)	1 үрэг										
В ТЕРАПИ	2 үрэг										
КАПЛАРТ САА	3 үрэг	4 үрэг	5 үрэг	6 үрэг	7 үрэг	8 үрэг	9 үрэг	10 үрэг	11 үрэг	12 үрэг	
КАВТ (САЛУУ, АНГУУН, ХАМД, ДЭЛЭГ, 1-8, 10, 11, 12) + ХАМДЛАХАД (АМЬСГАХАД)		1 үрэг	2 үрэг	3 үрэг	4 үрэг	5 үрэг	6 үрэг	7 үрэг	8 үрэг	9 үрэг	10 үрэг
ХАМДЛАХАД, ГЭЖИР, АНДЛАР, ХАМДЛАХАД (10%)											
САХУУ, ТАЛГАХ											

IMUNIZATION SCHEDULE

Төрөл	1 саягад	2 саягад	3 саягад	4 саягад	5 саягад	6 саягад	7 саягад	8 саягад	9 саягад	10 саягад
Бусадны нэр										
СҮРМЭЭ (52%)										
В ТЕРАПИ										
КАПЛАРТ САА										
КАВТ (САЛУУ, АНГУУН, ХАМД, ДЭЛЭГ, 1-8, 10, 11, 12) + ХАМДЛАХАД (АМЬСГАХАД)										
ХАМДЛАХАД, ГЭЖИР, АНДЛАР, ХАМДЛАХАД (10%)										
САХУУ, ТАЛГАХ										

ЭНЭГ ТӨВ ХАМГААГАХ АЖЛАА

МОНГОЛ



Дархлаажуулалтын
сангийн хөрөнгийг
журмын дагуу
зарцуулсан боловч,
зарцуулалтад тавих
дотоод хяналт
хангалтгүй байна.

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	3
Дундговь аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, аргазүй	4-5
Тэргүүлэх аудитор Т.ОЮУНЧИМЭГ	Бүлэг 3. Дархлаажуулалтын сангийн хөрөнгийг журмын дагуу зарцуулж байна	
Аудитын менежер Б.ГАНТУЯА	3.2. Вакцины захиалгыг журмын дагуу тооцоолоогүй, нотлох баримт хангалтгүй тул төлөвлөлтөнд дүгнэлт өгөх боломжгүй байна.	6-7
Шинжээч Д.ИХБАЯР Д.ДОЛЖИНСҮРЭН	3.3 Эрүүл мэндийн газартай дархлаажуулалтын сангаас олгодог вакцин, биобэлдмэлийг нийлүүлэх талаар гэрээ байгуулаагүй байна	7-9
	3.4 Дархлаажуулалтын сангаас 2014 онд хийгдэж байгаа төвлөлтийн вакцинд нийт хамрагдвал зохих хүүхдүүдийн 99.3% нь хамрагдсан байна.	9-16
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592225 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	Бүлэг 4. Дотоод хяналт хийсэн талаар нотлох баримт хангалтгүй байна.	
	4.1 Дархлаажуулалтын сангаар хийгдэж байгаа нийт вакцины 44.7% нь устгалд орж байна.	17-18
	Зөвлөмж	19
	Шалгагдагч байгууллагаас ирсэн санал тайлбар	20
	Аудитын газраас хийсэн тайлбар	21
	Тэргүүлэх аудиторын тушаал	22
	Тайлангийн хавсралтууд	23-31
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 2 давхар		
2015 оны 09 дүгээр сар		

ТОВЧИЛСОН ҮГС

ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ЗӨСҮТ	Зооноз өвчин судлалын үндэсний төв
ЭМГ	Эрүүл мэндийн газраас

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах” тухай 2014 оны 20 дугаар тогтоол, ҮАГ-аас 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, Дундговь аймгийн Аудитын газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилго, зорилт

Дархлаажуулалтын сангийн хөрөнгөөр Дундговь аймагт хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, сангийн хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Хууль, эрх зүйн зохицуулалт оновчтой эсэх,
- ❖ Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлсэн эсэх,
- ❖ Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг тайлагнасан эсэх,
- ❖ Дотоод хяналт үр нөлөөтэй эсэх,

3. Аудитын хамрах хүрээ

Аудитаар Сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын байдал, Дархлаажуулалтын сангаас 2014 онд санхүүжүүлсэн хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт, аймгийн дархлаажуулалтын сангаас татсан вакцин эм урвалж, зүү тариур, тоног төхөөрөмжийн хадгалалт хамгаалалттай танилцаж, бусад холбогдох баримт материал, бүртгэл тайлан мэдээг хамруулав.

4. Аудитын арга зүй

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүй, гарын авлагыг ашиглан, Тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв. Аудитаар байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа, тайлан мэдээг тулган баталгаажуулах зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүй, горимыг хэрэгжүүлэн нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулсан болно. Аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотолгоо, холбогдох шинжилгээ, судалгааг тайланд хавсаргав.

Аудитад ашигласан хууль, тогтоомж, шалгуур үзүүлэлт

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Төрийн хяналт шалгалтын стандарт
- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль

- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Дархлаажуулалтын журам
- Дархлаажуулалтын дүрэм
- Эрүүл мэндийн сайдын 2011.11.№359 тушаал
- Бусад холбогдох эрх зүйн актууд.

5. Аудит хийсэн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг аудитын менежер Б.Гантуяа хянан удирдаж, нийцлийн багийн шинжээч Д.Должинсүрэн 2015 оны 7 дугаар сарын 31-ны өдрөөс эхлэн 9 дүгээр сарын 20-ний өдрийг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэлээ.

6. Аудитын дүн, тайлан баталгаажуулалт:

Аудитыг 2 дугаар бүлгийн 2.1 асуудал, 3 дугаар бүлгийн 3.1 асуудалд хамаарагдаж байгаа тул тайланг энэ хүрээнд бэлтгэлээ.

Тайлангийн төслийг 2015 оны 9 дүгээр сарын 16-ны өдрөөс 9 дүгээр сарын 21-ны өдрүүдэд боловсруулан төслийг 2015 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 198 тоот албан тоотойр УАГ-т хүргүүлнэ.

Аудитад шаардлагатай судалгаа материал ирүүлэх тухай 2015 оны 07 сарын 31 өдрийн 174 тоот албан бичгийг Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн боловч баримт материал ирүүлээгүй тул дахин 2015 оны 9 сарын 16 нд 193 тоот албан бичгийг явуулсан. Энэ талаар шалтгааныг тодруулахад 2014 онд хариуцаж байсан ажилтан ажлаасаа гарсан, одоо өөр хүн хариуцаж байгаа бусад тайлан мэдээ баримтуудыг мэдэхгүй байна гэсэн тайлбар өгсөн.

Дээрх шалтгаануудаас баримт материал хугацаандаа бүрэн ирээгүй, одоо ажил хариуцаж байгаа мэргэжилтэн өмнөх ажлын талаар мэдээлэлгүй, мөн аудитын явцад хотруу семинарт явсан зэргээс шалтгаалж, аудит хийх нөхцөл бололцоо бүрэн бүрдүүлэхгүй, аудитыг хугацаанд нь гүйцэтгэхэд хүндрэл учруулж байлаа.

Бүлэг 3. Дархлаажуулалтын сангийн хөрөнгийг журмын дагуу зарцуулж байна

3.2. Вакцины захиалгыг журмын дагуу тооцоолоогүй, нотлох баримт хангалтгүй тул төлөвлөлтөнд дүгнэлт өгөх боломжгүй байна.

Вакцин зүү тариурын 2014 оны захилгыг ХӨСҮТ-ийн мэргэжилтэнд цахим хаягаар хүргүүлсэн гэх боловч албан тоот, баталгаажуулсан захиалгын хуудас зэрэг нотлох баримт байхгүй байна. Энэ нь Засгийн газрын 2001 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан Дархлаажуулалтын сангийн ажиллах журмын 12-д /Сэргийлэх тарилгад хамрагдах шаардлагатай ажил, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн ажиллагчдыг сэргийлэх тарилгад бүрэн хамруулах үүрэг хүлээж, тухайн жилд уг тарилгад хамрагдвал зохих хүмүүсийн судалгааг сэргийлэх тарилга тус бүрээр гаргаж хамрах хүрээний эмнэлэг, эрүүл мэндийн газарт жил бүрийн 1 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ./ гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аймгийн хэмжээгээр ХӨСҮТ-өөс 2014 нийт 72,728.6 мянган төгрөгийн үнэ бүхий вакцин, зүү тариур, тоног төхөөрөмж авсанаас 62,381.6 мянган төгрөгийн 32080 хүн/тун вакцин, 959.8 мянган төгрөгийн 9300 ширхэг зүү тариур, 3,660.0 мянган төгрөгийн 50 хүн/тун сорил, 187.0 мянган төгрөгийн 200 ширхэг аюулгүй хайрцаг, 4,835.0 мянган төгрөгийн 2 ширхэг вакцины хөлдөөгч, тог тохируулагчийн хамт авсан байна.

Дээрх вакцин, зүү тариур, тоног төхөөрөмжийг татан авахдаа 1,629.0 мянган төгрөгийн шатахууны зардал гаргаж 6 удаагийн /Хавсралт 3/тээвэрлэлтээр татан авсан байна.

ХӨСҮТ-ээс ирсэн падааны задаргаа вакцин, зүү тариураар /мянган төгрөгөөр/

Хүснэгт 1

Падааны огноо	Нийт падааны дүн	Падаанд ороогүй вакцины дүн	Вакцин	Сорил ийлдэс	Тариур	Аюулгүй хайрцаг
2014.02.07	14,165.7	705.0	13,825.3	148.5	192.0	
2014.04.06	13,482.6		13,329.4		112.9	40.4
2014.06.14	10,404.4		10,341.1		21.9	41.3
2014.08.14	6,133.5		3,092.2	3,000.0		41.3
2014.10.14	16,500.9		15,648.2	511.5	277.3	64.0
2014.12.14	6,501.4		6,145.4		355.8	
	67,188.5	705.0	62,381.6	3,660.0	959.9	187.1
	Нийт дүн				67,893.6	

Аудитын явцад 2014 оны вакцины захилга болон нийлүүлэлтийг тулган шалгаж үзэхэд захиалгын дагуу ХӨСҮТ-ээс 50 хүн/тун галзуугийн вакцин захиалгын хуудсанд бичигдэж

ирсэн боловч, 2014 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2014-38 тоот зарлагын падаанд 50 хүн/тун буюу 705.0 мянган төгрөгийн вакцин бичигдээгүй байна.

Вакцины хэрэгцээ шаардлагыг судлаж үздэггүй, захиалгыг албан ёсоор хүргүүлээгүй, зэрэг нь аймгийн ЭМГ-ын ажил хариуцсан мэргэжилтний ажлын хариуцлага байгууллагын дотоод хяналт хангалтгүйг харуулж байна. Энэ нь орон нутгийн иргэдийг дархлаажуулалтад бүрэн хамруулах боломжийг алдагдуулах эрсдлийг цаашид анхаарах шаардлагатай байна.

Дархлаажуулалтын сангаас авах вакцины захиалга хүргүүлсэн баримт байхгүй тул дархлаажуулалтын ажлыг хэрхэн зохион байгуулахаар төлөвлөснийг дүгнэх боломжгүй байна.

3.3 Эрүүл мэндийн газартай дархлаажуулалтын сангаас олгодог вакцин, биобэлдмэлийг нийлүүлэх талаар гэрээ байгуулаагүй байна

Дархлаажуулалтын сангийн ажиллах журмын 3.10-т Дархлаажуулалтын сангийн хөрөнгийг урьдчилан сэргийлэх тарилга, дархлаажуулах бэлдмэл, зүү, тариур, сэргийлэх бусад эм, урвалж худалдан авах, тэдгээрийг тээвэрлэх, түгээх зориулалтаар сангийн зөвлөлийн зөвшөөрсөн хэмжээгээр Халдварт өвчин судлалын үндэсний төв захиран зарцуулна. гэж заасны дагуу хөдөө орон нутагт вакцин, биобэлдмэлийг захиалах, ханган нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, нөөцлөх, хуваарилах асуудлаар аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газартай гэрээ байгуулан ажиллах ёстой боловч огт гэрээ байгуулаагүй байна. Энэ нь тус журмын 11.в-д /вакцин, биобэлдмэлийг захиалах, ханган нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, нөөцлөх, хуваарилах асуудлаар аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газартай гэрээ байгуулан ажиллана/гэж заасныг зөрчсөн байна.

- *Вакцины хадгалалт хамгаалалтын талаар*

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1997 оны 219 тоот тушаалаар батлагдсан Вакцины хүйтэн хэлхээний байнгын үйлчилгээ хяналтын журмын дагуу аймгийн эрүүл мэндийн төв дээр очиж үзэхэд 3 ширхэг хүйтэн хэлхээний төхөөрөмж ажиллаж байв.

Хөргөгч, хөлдөөгчийн хэмийг өдөр бүр өглөө, орой 2 удаа хөтөлдөг. Хөргөгчид С+2+8-д халдварт саа, сахуу хөхүүл ханиад, татрангийн 3-т, сахуу татрангийн 2-т болон В гепатитын вакцинуудыг хадгалж, хөлдөөгчид С-15-25 градусуас буулгалгүй хадгалдаг нь хөдөлгөөний дэвтэрт тэмдэглэгдсэн байна. Цахилгаан тасарсан үед тагийг нь нээлгүй байхад 6 цаг барих боломжтой, цахилгаан удаан хугацаагаар тасарсан тохиолдолд нөөц моторыг ажиллуулдаг байна. 2014 онд цахилгаан тасалдлаас шалтгаалсан вакцины устгал гараагүй байна.

Хүйтэн хэлхээний төхөөрөмжийн 2014 оны тэмдэглэлийг шалгахад:

- хүйтэн хэлхээний төхөөрөмжийн температурын заалт,
- цахилгааны тасалдал гараагүй тухай тэмдэглэл
- хөлдөөгч, хөргөгчийн температурын заалт нь стандартын дагуу байсан эсэхийг цаг тухайд нь шалгаж тэмдэглэлийг бүрэн хөтөлсөн байна.

2015 оны вакцин хадгалалтын хяналтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт2

Утга	Огноо	Унтраасан цаг	Мотор асаасан цаг
Тог тасарсан	2015.05.20	07.00-20.00	09.00-20.00
Тог тасарсан	2015.05.21	07.00-20.00	09.20-20.00
цэвэрлэгээ хийсэн	2015.06.26	10.00-11.30	
цэвэрлэгээ хийсэн	2015.07.29	11.30-12.40	
Хөлдөөгч хооронд эм зөөсөн	2015.08.04	09.20-09.30	

2015 оны бүртгэлээс харахад 2 удаа тог тасарч 2 удаа цэвэрлэгээ хийж нэг удаа хөлдөөгчийн эмийг зөөсөн байна.

/Зураг 1/



Аудитын явцад хөргөгчийн ажиллагааг шалгаж үзэхэд хөргөгч бүрт температур хэмжигч, температурын өөрчлөлтийг харуулах илтэс байрлуулсан байв.

ХӨСҮТ-ээс 2015 онд олгосон вакцин хадгалах Дани улсын МК-074 маркын 2 хөргөгчийг 2015 оны 01 сарын 16 –ны өдрийн А/06 дугаар тушаалаар Сайхан-Овоо, Дэрэн сумдын эрүүл мэндийн төвийн дархлаажуулалтын кабинетэд хуваарилсан байна.

Дундговь аймгийн хэмжээний хөргөгчний судалгаа

Хүснэгт 3

№	Сумдууд	Олгосон огноо		Үйлдвэрлсэн улс, марк		Модель				
		Хятад-Нair	Дани-vestfrost	Хятад-Нair	Дани-vestfrost	МК-74	НВС-70	НВС-200	МК-144	МК-304
1	Дэлгэрцогт	1997	2012	1	1	1	1			
2	Дэрэн		2001 2015		2	2				
3	Говьугтаал	1997	2012	1	1	1		1		
4	Цагаандэлгэр	1997	2012	1	1	1	1			
5	Баянжаргалан	1999	2012	1	1		1		1	

6	Өндөршил	1998	2012	1	1	1	1			
7	Гурвансайхан		1999		1				1	
8	Өлзийт		2003		1	1				
9	Хулд	1998	2012	1	1	1		1		
10	Луус	1998	2012	1	1	1	1			
11	Дэлгэрхангай	1998	2012	1	1	1	1			
12	Сайхановоо		1999 2015		2	2				
13	Эрдэнэдалай	1997	2012	1	1	1		1		
14	Адаацаг	1998	2012	1	1	1	1			
15	Сайнцагаан ЭМТ		2000 2012		2	2				
16	Сайнцагаан Төрөх		2001		1	1				
17	Сайнцагаан ЭМГ	2012	2011	1	2	1		1		1
18	Сайнцагаан БГХӨГТ		2003		1	1				
	Дүн			11	22	19	7	4	2	1
	Нийт дүн			33		33				

Аймгийн хэмжээнд 1996 оноос хойш дархлаажуулалтын сангаас нийт 38 хөргөгч ирсний эвдэрч ажиллагаагүй болсон 5 хөргөгчийг акталж, одоогийн байдлаар 15 суманд 33 хөргөгч хэвийн ажиллаж байна.

Нийт ажиллаж байгаа хөргөгчийн:

- 11 буюу 33.3% нь хятад улсын Haier брэндийнх, /7 нь HBC-70 моделийн, 4 нь HBC-200 моделийн/ хөргөгч,
- 22 буюу 66.7% нь Дани улсын Vestfrost брэндийнх, /19 нь МК-74 моделийн, /2 нь МК-144 моделийн, 1 нь МК-304 моделийн/хөргөгч байна.

Эдгээр хөргөгчийн 16 буюу 48% хувь нь 1997-2003 онууд ашиглаж эхэлсэн 12-18 жил ашиглагдсан байна. Ашиглагдах хугацаа дууссан хөргөгчийг 2012 оноос солих арга хэмжээ авч 11 сумын 12 хөргөгчийг, 2014 онд 2 сумын хөргөгчийг шинэчилсэн байна.

Хөргөгчийн хэрэгцээ шаардлага, ашигласан хугацааг судлаж үзэхэд одоогийн байдлаар Гурвансайхан сум 16 жил, Дэрэн сум 12 жил ашигласан ашиглалтын хугацаа дууссан хөргөгчтэй, аймгийн Эрүүл мэндийн газарт 2 хөргөгч шинээр авах шаардлагатай бөгөөд аймгийн хэмжээнд нэн түрүүнд 4 ширхэг вакцины хөргөгч хэрэгцээтэй байна.

3.4 Дархлаажуулалтын сангаас 2014 онд хийгдэж байгаа товлалтын вакцинд нийт хамрагдвал зохих хүүхдүүдийн 99.3% нь хамрагдсан байна.

Дархлаажуулалтын сангаас дараах вакцин хийгддэг. Үүнд:

- заавал хийх дархлаажуулалтын товлалт вакцин,
- сэргийлэх тарилгад хамрагдах шаардлагатай ажил, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагсад сайн дураар төлбөртэй хийх вакцин,

- тархвар судлалын заалтаар заавал хийх төлбөргүй вакцинуудыг хийлгэх ёстой.

Сэргийлэх тарилгад хамрагдах шаардлагатай ажил, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудаас 2013 онд ажиллагсадаа вакцинд хамруулах талаар санал авахад төлбөр мөнгө төсөвт байхгүй тул боломжгүй гэсэн хариуг өгсөн байна. Энэ шалтгаанаар 2014 онд дархлаажуулалтын вакцинд сайн дураар хамруулах ажил зохион байгуулаагүй, төлбөртэй вакцин огт хийгдээгүй байна.

Харин тархвар судлалын заалтаар боом болон тарваган тахлын вакциныг 149 хүнд хийсэн байна.

Боомын вакцин.

Боомын вакциныг 2014 онд зөвхөн Сайнцагаан сумын заавал хамрагдах нийт 39 хүнд хийснээс эхний тунд 100 хувь бүрэн хамрагдаж, 2 тун-д 31 хүн буюу 79.5 хувь хамрагдаж үлдсэн 8 хүн нь ээлжийн амралттай байсан учраас хийлгээгүй байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4

Байгууллагын нэр	Хамрагдах ёстой хүн	Хамрагдсан /тун 1/	Хамрагдсан /тун 2/
ОБХ	31	31	27
ЗӨСТ	2	2	2
Мал эмнэлэг	4	4	3
Халдварт	2	2	1
нийт хүн	39	39	31

Боомын вакцинд хамрагдсан хүмүүсийг хүйс болон насны байдлаар харуулбал

График 1



Тарваган тахалын вакцин

Эүүл мэндийн сайдын тушаалын дагуу Тарваган тахлын эсрэг дархлаажуулалтыг долоодугаар сард хийдэг байна. Дархлаажуулалтыг явуулахаар Казахстан улсад үйлдвэрлэсэн тарваган тахлын эсрэг вакциныг тарваган тахлын голомтот нутгийн хүн ам,

малчид, эрүүл мэндийн байгууллага, онцгой байдал, мэргэжлийн хяналт, хууль сахиулах байгууллагын ажилтнууд зэрэг эрсдэлт бүлгийн хүмүүсийг хамруулсан байна.


2014 онд тарваган тахалын вакцинд хамрагдсан иргэдийн судалгаа

Хүснэгт 5

Байгууллагын нэр	Хамрагдах хүмүүс	Хамрагдсан хүмүүс
Эрүүл мэндийн ажиллагсад	22	22
Тарваган тахлын цэвэр өсвөр, туршилтын амьтад болон халдварын сэжигтэй материалтай ажиллагсад	40	6
Мэргэжлийн болон хууль сахиулах байгууллагын ажилчид	84	64
Тарваган тахлын түүхий эдтэй ажиллагсад болон боловсруулалт хийдэг хүмүүс		
Малчид		
Оюутан сурагчид	20	2
Бусад	34	16
нийт хүн	200	110

Тарваган тахлын вакцинд хамрагдсан иргэдийн насны судалгаа

График 2



Тарваган тахлын вакцинд хамрагдвал зохих 200 хүнээс 110 хүн буюу 55% нь хамрагдсан байна. Энэ вакциныг сайн дураар болон эрсдэлтэй бүлгийн хүмүүс хийлгэдэг бөгөөд зар мэдээлэлээ хүргэж чадаагүйгээс хамрагдалтын тоо хангалтгүй байна.

Тархвар судлалын заалтаар хийгдсэн вакцины баланс /хүн/тун/

Хүснэгт 6

Д. д	Вакцины нэр	Эхний үлдэг дэл (хүн/ тун)	ХӨСҮТ- ээс татан авсан (хүн/ тун)	Зарлага (хүн/ тун)	үүнээс					Эцсийн үлдэг дэл (хүн/ тун)
					Тарьсан (хүн/ тун)	Тарих үеийн техник ажиллага анаас	үүнээс			
							Найруулаа д устгасан (хүн/тун)	Хугацаа дуусч устгасан	Устгалд оруулсан (хүн/тун)	
	Боом		180	80	70		10			100
	Тарваган тахал		200	160	110		50			40
	нийт дүн		380	240	180	0	60	0	0	140

Хүснэгт 8-аас харахад нийт 380 хүн/тун вакцинаас найруулаад устгасан вакцин нь 60 хүн/тун буюу 15%-ийг эзэлж байна. Мөн тарваган тахлын вакцинд нийт хамрагдах хүмүүсийн дөнгөж 55% хамрагдаж 25% устгалд орсноос үзвэл хамрагдвал зохих хүмүүсийг зөв зохион байгуулж чадаагүйтэй холбоотой байна.

Заавал хийх дархлаажуулалтын товлолын вакцин

2014 онд товлолын нийт 10 төрлийн вакцин хийгдсэн байна. 2013 оны нийт үлдэгдэл 7537 хүн/тун вакцин дээр ХӨСҮТ-ээс 32080 хүн тун вакцин татаж нийт 39617 хүн/тун вакцинаас 82.7% буюу 32774 хүн/тун зарлагдсан байна. Үүний 14955 хүн/тун 45.6%-ийг тарьж, 54.4% хүн /тунг, 17819 хүн тунг устгалд оруулжээ.

Вакцины баланс /хүн/тунгаар /

хүснэгт 7

Вакцины нэр	Эхний үлдэг дэл	ХӨСҮ Т-ээс татан авсан	Зарла га	Үүнээс					Эцсий н үлдэг дэл
				Тарьса н	үүнээс				
					Тарих үеийн техник ажилла гаанаас	Найру улаад устгас ан	Хугаца а дууссан аас устгаса н	Устгал д оруулс ан	
Сүрьеэгийн вакцин	700	11200	9500	948	0	8432	120	8552	2400
Халдварт саагийн вакцин	510	8000	6200	3791	0	2409	0	2409	2310
/MMR-ийн 3-т вакцин, улаанууд /	1745	4000	6345	1801	0	3170	1374	4544	340
5-т вакцин	2835	2800	4365	2843	143	0	1379	1522	330
Гепатит В-ийн вакцин	380	1480	1607	948	0	659	0	659	253
А гепатит вакцин	448	1600	1808	1808	0	0	0	0	240
Галзуу	69	700	709	709					60
Сахуу татран	100	1600	1490	1357		133		133	210
Менингит	50		50	50					
Томуу	700	700	700	700					700
Нийт	7537	32080	32774	14955	143	14803	2873	17819	6843

Нийт устгалд оруулсан вакцины 0.8 хувь нь тарих үеийн техник алдаанаас, 83 хувь нь найруулаад устгасан, 16.2 хувийг хугацаа дууссан тул устгасан байна.

Вакцины баланс /мянган төгрөгөөр/

хүснэгт 8

Вакцины нэр	Эхний үлдэгдэл	ХӨСҮТ- ээс татан авсан	Зарлага	Зарлагдсан вакцин					Эцсийн үлдэгдэл
				Тарьсан	үүнээс				
					Тарих үеийн техник ажиллага анаас	Найруула ад устгасан	Хугацаа дууссанаа с устгасан	Устгалд оруулсан	
Сүрьеэгийн вакцин	80.9	2,621.80	1,988.00	198.40		1,764.50	25.1	1,789.60	714.70
Халдварт саагийн	181.2	3,063.80	2,296.60	1,404.30		892.3		892.30	948.40
/MMR-ийн 3-т вакцин, улаанууд /	2,756.00	7,591.00	9,547.70	2,710.10		4,770.10	2,067.50	6,837.60	799.30
5-т вакцин	10,624.20	11,722.10	20,813.10	13,556.00	681.8		6,575.30	7,257.10	1,533.20
Гепатит В-ийн вакцин	843.4	489.6	1,231.70	726.60		505.1		505.10	101.30
А гепатит вакцин	6,406.40	22,880.00	25,854.40	25,854.40				0.00	3,432.00
Галзуу	273.2	9,166.10	8,593.30	8,593.30				0.00	846.00
Сахуу татран	18.5	506.9	458.9	418.00		40.9		40.90	66.50
Менингит	192.5		192.5	192.50				0.00	0.00
Томуу	4,200.00	4,340.00	4,200.00	4,200.00				0.00	4,340.00
Нийт	25,576.3	62,381.3	75,176.2	57,853.6	681.8	7,972.9	8,667.9	17,322.6	12,781.4

Аймгийн хэмжээнд 2014 оны эхний үлдэгдэл 25,576.3 мянган төгрөгийн вакцин дээр 62,381.3 мянган төгрөгийн вакцин орлого авч, 75,176.2 мянган төгрөгийн вакциныг зарцуулсан байна. Дээрх зарцуулсан вакцинаас 57,853.6 мянган төгрөгийн вакциныг тарьж, 17,322.6 мянган төгрөгийн вакциныг устгасан байна.

Дундговь аймагт 2014 онд нийт 948 хүүхэд төрсөн бөгөөд 0-2 хүүхдийн нас баралт 19 буюу нийт төрөлтийн 0,02% нь нас барсан байна. Дөнгөж төрөөд 6 хүүхэд, 1 сартай-1 хүүхэд, 2 сартай 2 хүүхэд, 4 сартайдаа-2 хүүхэд, 5 сартайдаа-2 хүүхэд, 6 сартайдаа-1 хүүхэд, 7 сартайдаа -2 хүүхэд, 11 сартайдаа-1 хүүхэд, 1 настайдаа-1 хүүхэд, 3 настайдаа-1 хүүхдүүд нас барсан байна. Үүнийг сумдуудаар авч үзвэл:

хүснэгт 9

№	Сумдууд	Төрсөн хүүхэд	Нас баралт
1	Дэлгэрцогт	27	1
2	Дэрэн	42	
3	Говьугтаал	42	
4	Цагаандэлгэр	4	1
5	Баянжаргалан	14	1
6	Өндөршил	20	1
7	Гурвансайхан	41	
8	Өлзийт	51	
9	Хулд	46	1

10	Луус	34	
11	Дэлгэрхангай	44	
12	Сайхановоо	25	
13	Эрдэнэдалай	107	
14	Адаацаг	52	
15	Сайнцагаан	399	14
		948	19

Аймгийн хэмжээгээр төрсөн нийт 948 хүүхдийн 6 төрлийн вакцинд хамрагдалтыг авч үзвэл:

1. Сүрьеэгийн вакцин 948 хүүхэд 100%
2. В Гипатетийн вакцин 948 хүүхэд 100%
3. Халдварт саа 0 эхний - 100%, 1 давталт -99%, 2 давталт-98.6, 3 давталт-98.7, нийт дүнгээр 99%
4. 5-т вакцин 1 эхний -99%, 2 давталт -98.6%, 3 давталт-98.7% нийт дүнгээр 98.8%
5. 3-т вакцин 1 эхний -99.4%, 2 давталт -99.5% нийт 99.4%
6. А гипатет 1 эхний -97.9%, 2 давталт -99.6% нийт дүнгээр 98.7%

Дээрх эхний 3 вакциныг дөнгөж төрөхөд эхний тунг хийдэг бөгөөд дараа дараагийн тунг вакцин бүрт тодорхой сар болон настайд хийдэг байна. Нийт дүнгээрээ товлолтын вакцины хамралт 99.3%-тай, сайн дүнтэй гарсан байна. Харин Сахуу татрангийн хоргүйсүүр вакциныг 7-14 настайд нь 10 сард хийдэг бөгөөд ерөнхий боловсролын сургуулиар явж хийсэн байна. Энэ вакцины хамрагдалт эхний тун 1-т 86.5%, 2 дах тунд 86% нийт дүнгээр 86.3 % нь хамрагдсан байна.

2014 оны заавал хийх дархлаажуулалтын хамралт аймгийн хэмжээнд /1 нас хүртлэх/

Хүснэгт 10

Насны ангилал	Сүрьеэгийн вакцин		В гепатит		Халдварт саагийн вакцин								5-т вакцин						УГУ		Шилжилт		
					0		1		2		3		1		2		3		1				
	Хамрагдах хүүхэд	Хамрагдсан	Хамрагдах хүүхэд	Хамрагдсан	Хамрагдах хүүхэд	Хамрагдсан	Хамрагдах хүүхэд	Хамрагдсан	Хамрагдах хүүхэд	Хамрагдсан	Хамрагдах хүүхэд	Хамрагдсан	Хамрагдах хүүхэд	Хамрагдсан	Хамрагдах хүүхэд	Хамрагдсан	Хамрагдах хүүхэд	Хамрагдсан	Ирсэн хүүхдийн тоо	Явсан хүүхдийн тоо	Нас барсан		
0	948	948	948	948	948	948													10		6		
1сар																					6		
2сар							952	943							952	943			120	134	1		
3сар									973	952							973	952		135	93	2	

Хүснэгт 11

Хүснэгт 12

15

6	Өндөршил	20	20	20	20	20	20	23	23	23	23	29	29	23	23	23	23
7	Гурвансайхан	41	41	41	41	41	41	29	26	28	26	27	25	29	26	28	26
8	Өлзийт	51	51	51	51	51	51	43	43	45	45	50	50	43	43	45	45
9	Хулд	46	46	46	46	46	46	46	46	47	46	49	48	46	46	47	46
10	Луус	34	34	34	34	34	34	26	26	28	28	26	26	26	26	28	28
11	Дэлгэрхангай	44	44	44	44	44	44	49	49	52	52	54	54	49	49	52	52
12	Сайхановоо	25	25	25	25	25	25	30	30	36	36	30	29	30	30	36	36
13	Эрдэнэдалай	107	107	107	107	107	107	127	127	146	146	142	142	127	127	146	146
14	Адаацаг	52	52	52	52	52	52	44	44	50	49	53	52	44	44	50	49
15	Сайнцагаан	399	399	399	399	399	399	374	369	360	345	345	338	374	369	360	345
	Аймгийн дүн	948	948	948	948	948	948	952	943	973	952	961	948	952	943	973	952
	Хувь	100%	100%	100%	100%	100%	100%	99%	97.80%	97.80%	97.80%	98.60%	99%	99%	97.80%	97.80%	97.80%

Сүрьеэ, В гепатит, Халдварт саагийн 0- давталтыг бүх сум 100%, Халдварт саагийн вакциныг 1-р давталтыг Гурвансайхан сум 89.7%, Дэрэн сум 97.7%, Сайнцагаан сум 98.7%-ийн хамрагдуулалтаар сүүлийн 3 байрт орж бусад бүх сум 100% хамруулсан байна. Халдварт саагийн 2 давталтыг Дэлгэрцогт 96.7%, Дэрэн 97.9%, Гурвансайхан 92.9%, Хулд 97.9%, Адаацаг 98%, Сайнцагаан 95.8%-тай, Халдварт саагийн 3-р давталтыг Дэлгэрцогт 97%, Гурвансайхан 92.6%, Хулд 98%, Сайхановоо 96.6%, Адаацаг 98.1%, Сайнцагаан 98%-тай, 5-т вакциныг Дэрэн 97.7%, Гурвансайхан 89.7%, Сайнцагаан 95.8%-тай байна.

Гурвансайхан сум Халдварт саагийн 1,2,3-р давталт, 5-т вакцины 1,2-р давталтаар нийтдээ 91.56 хувь хамрагдсан нь хамгийн бага үзүүлэлттэй байна.

Бүлэг 4. Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байна.**4.1 Дархлаажуулалтын сангаар хийгдэж байгаа нийт вакцины 44.7% нь устгалд орж байна.**

Эрүүл мэндийн сайдын 2011 оны 11 сарын 07 өдрийн 359 дүгээр тушаалаар вакцин, биобэлдмэлийн хаягдлыг устгах журамын дагуу Эрүүл мэндийн газрын даргын 2014 оны 04 сарын 25 өдрийн комисс байгуулах тухай А/45 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй Вакцин биобэлдмэлийн хаягдлыг устгах устгалын комисс байгуулагдсан байна. Тус комисс нь Вакцин биобэлдмэлийн хаягдлыг устгах журам-ыг мөрдөн ажиллаж, устгасан тохиолдол бүрт устгалын акт үйлдэн тухай бүр Халдварт өвчин судлалын үндэсний төвд сар болгоны мэдээгээр мэдээлж ажилласан байна.

Хаягдлыг устгах дараах нөхцөлүүд үүсдэг байна. Үүнд:

- Вакцин биобэлдмэлийн хүчинтэй хугацаа дууссан,
- ампул, флакон цуурч хагарсан,
- шошго унасан эсвэл уншигдахгүй болсон, өнгө өөрчлөгдсөн, тунадас үүссэн,
- халуун хүйтний нөлөөллөөр гэмтсэн,
- тээвэрлэлтийн явцад хөлдсөн задалсан
- вакцин, биобэлдмэлийн 24 цагийн дотор хийгдээгүй хаягдал

Аймгийн хэмжээний устгалын дүн

Хүснэгт 13

№	Вакцины нэр	нийт устгалд орсон	Үүнээс		
			Найруулаад устгасан (хүн/тун)	Хугацаа дууссанаас устгасан (хүн/тун)	Тарих үеийн техник ажиллагаанаас
1	Серьеэгийн вакцин	8552	8432	120	
2	Халдварт саагийн вакцин	2409	2409	0	
3	MMR-ийн 3-т вакцин	3604	3170	434	
4	5-т вакцин	1522	0	1379	143
5	Гепатит В-ийн вакцин	659	659	0	
6	А гепатит вакцин	0	0	0	
7	Галзуу	0			
8	сахуу татран	133	133		
9	Менингит	0			
10	Улаанбурхан улаанууд	940		940	
11	Томуу	0			
12	Боом	10	10		
13	Тарваган тахал	50	50		
	нийт	17879	14863	2873	143

Аймгийн хэмжээнд 2014 онд нийт 13 төрлийн 39997 хүн/ тун вакцин хийснээс 17879 хүн/тун буюу 44.7% -ийг устгалд оруулсан байна.

Нийт устгасан вакцины:

- 83.1% - нь найруулаад устгасан вакцин,
- 16% нь хугацаа дууссан вакцин,
- 0.9%-нь техник алдаа буюу тариур нь гацаатай, эвдрэлтэй, өөрөө эвхэгддэг тариур нь шууд эвхэгдэх зэргээс хамааран тарих үеийн техник ажиллагаанаас болж устгалд орсон байна.

Найруулаад устгасан вакцины хувь өндөр гарч байгаа нь вакциныг найруулаад 24 цагийн дотор л хэрэглэх заалттай байдаг, найруулсан үед хүүхэд ирэхгүй бол устгалд оруулдагтай холбоотой байна.

Хүснэгтээс харахад Сүрьеэ /бцж/ вакцин хамгийн их 8432 хүн/ тун буюу 57.5% эзэлж байгаа нь нэг шил ампулдаа 20 хүн/ тун найрагддаг, тухайн суманд өдөрт нэг хүүхэд төрөхөд 20 хүн/ тун найрагдаад нэг нь хийгдэж, үлдсэн 19 хүн/тун устгадаг учраас өндөр хувьтай байна. Халдварт саагийн вакцин болон Гепатит В-ийн вакцинуудын нэг ампул нь 10 хүн/тунаар найрагддаг бөгөөд нийт устгалын 20.9 %-ийг эзэлж байна. Хамгийн бага устгалтай Гепатит В-ийн вакцин 659 ширхэг буюу 4.3 %-ийг эзэлж байна. MMR-ийн 3-т вакцины нэг ампул нь 5 хүн/тунгаар найрагддаг бөгөөд нийт устгалын 21.6 %-ийг эзэлж байна. 5-т вакцин, А гепатит вакцинууд нэг хүн тунаар найрагддаг учраас найруулаад устгасан устгал байхгүй байна.

Устгалыг сумдаар нь 6 төрлийн гол нэрийн вакцинаар харуулбал

Хүснэгт 13

Вакцины нэр	Дэлгэрцогт	Дэрэн	Говьугаал	Цагаандэлгэр	Баянжаргалан	Өндөршил	Гурвансайхан	Өлзийт	Хулд	Луус	Дэлгэрхангай	Сайхановоо	Эрдэнэдалай	Адаацаг	Сайнцагаан	Аймгийн дүн
Сүрьеэ /бцж/	133	78	118	16	86	0	119	49	34	66	296	175	713	68	6481	8432
Халдварт саагийн вакцин	149	185	135	121	300	135	172	61	114	156	71	130	38	163	479	2409
MMR-ийн 3-т вакцин	123	282	130	130	146	102	196	178	111	85	179	299	284	282	643	3170
5-т вакцин	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Гепатит В-ийн вакцин	23	28	48	46	66	40	49	69	34	36	16	25	63	28	88	659
А гепатит вакцин	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Нийт	428	573	431	313	598	277	536	357	293	343	562	629	1098	541	7691	14670

Вакцин, биобэлдмэлийг тээвэрлэн, устгасан тухай актуудыг түүвэрлэн шалгахад актанд комиссын гишүүдийн гарын үсэг зурагдаагүй зөрчил нийтлэг байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дээрх судалгааг сум болгоны сарын мэдээнээс түүж дүнг гаргасан бөгөөд 2014 оны вакцины балансыг сумдаар гаргаагүй шалтгааныг тодруулахад:

1. Тухайн санг хариуцаж байсан ажилтан солигдсон бөгөөд хийж байсан хүн нь давхар ажил хавсардаг
2. Дархлаажуулалтын сангаар хийгддэг вакцины программ нь 2014 оны 10 сард анх суулгуулсан ч компьютерийн хүчин чадал нь дийлэхгүй эвдэрсэн гэсэн тайлбар өгсөн.

Сумдын дархлаажуулалтын сангаар хийгдсэн вакцины үйл ажиллагаанд ЭМГ-аас хяналт хийдэг гэх боловч нотлох баримт байсангүй.

ЗӨВЛӨМЖ

Аудитын үр дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Эрүүл мэндийн газарт:

1. Вакцин, биобэлдмэлийг захиалах, ханган нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, нөөцлөх, хуваарилах асуудлаар ХӨСҮТ-тэй гэрээ байгуулж, дүгнэж, үр дүнг тооцож хэвших
2. Вакцины захиалгыг журмын дагуу тооцоолж баримтжуулах
3. Вакцины захиалга, мэдээ тайлан, бусад баримтуудыг баталгаажуулан үдэж цэгцлэх
4. Вакцины зарцуулалтанд тавих дотоод хяналтыг сайжруулах, устгалын актыг бүрэн, үнэн зөв үйлдэж хэвших

ТАЙЛАН БИЧСЭН:

ШИНЖЭЭЧ

Д.ДОЛЖИНСҮРЭН

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг
Утас/Факс: 70-59-38-942015.09.24 № 470
танай 2015.09.22 -ны № 199 -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Манай дархлаажуулалтын үйл ажиллагаанд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан дараах тайлбарыг хүргүүлж байна.

1. Вакцин, биобэлдмэлийг захиалах, ханган нийлүүлэх, хадгалах тээвэрлэх, нөөцлөх талаар ХӨСҮТ –тэй гэрээ хийгээгүй ч уг үйл ажиллагааг ЭМС-ын 2011 оны 04 сарын 11-ний өдрийн 122 тоот тушаалын дагуу мөрдөн ажилладаг.
2. Эрүүл мэндийн газрын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн гэсэн орон тоо байдаггүй тул уг ажлыг халдварт өвчин хариуцсан мэргэжилтэнд хавсруулан ажиллуулдаг.

ДАРГА  ЭНХСАЙХАН IX/24

My Documents /toot-A-5/

АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

Төрийн Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2-т заасны дагуу аудитын тайлангийн төсөлд дараах тайлбарыг өгч байна. Үүнд :

<i>Эрүүл мэндийн газраас ирүүлсэн санал, тайлбарт өгөх Аудитын газрын тайлбар</i>	
Тайлбар 1	Засгийн газрын 2001 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан Дархлаажуулалтын сангийн ажиллах журмын 11.в-т / вакцин, биобэлдмэлийг захиалах, ханган нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, нөөцлөх, хуваарилах асуудлаар аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газартай гэрээ байгуулан ажиллана;/гэсэн заалт хэрэгжихгүй байна. Энэ талаар Бүлэг 3.3-т /Дархлаажуулалтын сангийн хөрөнгийг урьдчилан сэргийлэх тарилга, дархлаажуулах бэлдмэл, зүү, тариур, сэргийлэх бусад эм, урвалж худалдан авах, тэдгээрийг тээвэрлэх, түгээх зориулалтаар сангийн зөвлөлийн зөвшөөрсөн хэмжээгээр Халдварт өвчин судлалын үндэсний төв захиран зарцуулна. Үүний дагуу хөдөө орон нутагт вакцин, биобэлдмэлийг захиалах, ханган нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, нөөцлөх, хуваарилах асуудлаар аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газартай гэрээ байгуулан ажиллах ёстой боловч огт гэрээ байгуулаагүй байна./ гэж бичигдсэн байгаа тул байгууллага тус бүрийн тайлбарыг тайланд тусгах боломжгүй.
Тайлбар 2	Тайлбартай танилцлаа. Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2015 оны 9 сарын 25 өдөр

Дугаар А/30

Мандалговь

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7 дах заалт, Гүйцэтгэлийн шалгалтын журмын 23 дугаар зүйлийн 2, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Дархлаажуулалтын сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Дархлаажуулалтын сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсүгэй.

Гурав. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилган, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2014 оны 10 дүгээр сарын 20-ны дотор Аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн газрын дарга Ц.Энхсайхан, Дархлаажуулалтын санг хариуцсан мэргэжилтэн Г.Улааннаран нарт зөвлөсүгэй.

Тав. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг шинжээч Д.Должинсүрэнд даалгасугай.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ОЮУНЧИМЭГ

000000007*

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

Аудитын код: ҮАГ-НАГ /2015/03-НА	
----------------------------------	--

Дундговь аймгийн Дархлаажуулалтын сангийн талаарх судалгаа / төгрөгөөр/

Д/д	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар	Дархлаажуулалтын сангаас эрүүл мэндийн газруудад олгогдсон вакцин, зүү, тариур, биобэлдмэл, эм урвалж, хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн тоо хэмжээ, үнэ				Вакцины хамраглалт /хүний тоогоор/	Сэргийлэх тарилгад хамрагдах шаардлагатай ажил, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын	Тарваган тахал өвчний голомт бүхий нутгийн малчдын сэргийлэх тарилгын хамраглалт /хүний тоогоор/
		ВАКЦИНЫ	ЗҮҮ, ТАРИУР	БИОБЭЛДМЭЛ	ЭМ, УРВАЛЖ			

1	Дундговь	32080	63,086,697.8	9300	959881	200	187057	50	3,660,00	2	4835048	15327	15135				
---	----------	-------	--------------	------	--------	-----	--------	----	----------	---	---------	-------	-------	--	--	--	--

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2014 ОНД САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙН СУДАЛГАА

							(сая төгрөг)	
№	Төсөл, арга хэмжээний нэр	Дархлаажуулалтын сангийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө			2014 он		Тайлбар, тодруулга	
		Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Батлагдсан санхүүжих дүн	Санхүүжүүлсэн дүн		
A	1	2	3	4	5	6	7	
1	Вакцин хөргөгч					4.8	Хөргөгч болон тог тохируулагчийн үнэ орсон	
2	Вакцин зүү тариур					67.18	аюулгүй хайрцаг, сорилын үнэ орсон	
3	Шатахууны зардал					1.6	Товлолын вакцины 6 удаагийн таталтын шатахууны зардал	

2014 онд Дархлаажуулалтын сангийн вакцин, зүү тариур татсан шатахууны зардлын тоо

№	Огноо	Машины дугаар	Жолоочийн нэр	Шатахууны төрөл	Нэг бүрийн үнэ	Хэмжээ	Бүгд үнэ
1	2014.02.07	44-35 УНЛ	М.Ганбаяр	АИ-92	1810	160	289,600
2	2014.04.06	44-35 УНЛ	М.Ганбаяр	АИ-92	1810	140	253,400
3	2014.06.14	44-35 УНЛ	М.Ганбаяр	АИ-92	1810	160	289,600
4	2014.08.14	44-35 УНЛ	М.Ганбаяр	АИ-92	1810	140	253,400
5	2014.10.14	44-35 УНЛ	М.Ганбаяр	АИ-92	1810	140	253,400
6	2014.12.14	44-35 УНЛ	М.Ганбаяр	АИ-92	1810	160	289,600
		Нийт				900	1,629,000

Дархлаажуулалтын вакцины баланс

/тоо хэмжээгээр/

Вакцины нэр	Эхний үлдэгдэл (хүн/тун)	ХӨСҮТ- ээс татан авсан (хүн/тун)	Зарлага (хүн/тун)	үүнээс					Эцсийн үлдэгдэл (хүн/тун)
				Тарьсан (хүн/тун)	үүнээс				
					Тарих үеийн техник ажиллагаанаас	Найруулаад устгасан (хүн/тун)	Хугацаа дууссанаас устгасан (хүн/тун)	Устгалд оруулсан (хүн/тун)	
Үндэсний товлолт вакцин									
Сүрьеэгийн вакцин	700	11200	9500	948	0	8432	120	8552	2400
Халдварт саагийн вакцин	510	8000	6200	3791	0	2409	0	2409	2310
/MMR-ийн 3-т вакцин, улаанууд /	1745	4000	6345	1801	0	3170	1374	4544	340
5-т вакцин	2835	2800	4365	2843	143	0	1379	1522	330
Гепатит В-ийн вакцин	380	1480	1607	948	0	659	0	659	253
А гепатит вакцин	448	1600	1808	1808	0	0	0	0	240
Галзуу	69	700	709	709					60
Сахуу татран	100	1600	1490	1357		133		133	210
Менингит	50		50	50					
Томуу	700	700	700	700					700
Дүн	7537	32080	32774	14955	143	14803	2873	17819	6843
Тархвар судлал									
Боом		180	80	70		10			100
Тарваган тахал		200	160	110		50			40
Дүн		380	240	180	0	60	0	0	140
Нийт	7537	32460	33014	15135	143	14863	2873	17819	6983

		Дархлаажуулалтын сангийн талаарх судалгаа									
Д/д	Сумдын эрүүл мэндийн төв	Аймгийн эрүүл мэндийн газраас сумдын эрүүл мэндийн төв, эмнэлэгүүдэд олгосон вакцин, зүү, тариур, биобэлдмэл, эм урвалж, хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн тоо хэмжээ, үнэ									
		вакцин		зүү, тариур		биобэлдмэл		эм урвалж		тоног төхөөрөмж	
		тоо	үнэ	тоо	үнэ	тоо	үнэ	тоо	үнэ	тоо	үнэ
1	Дэлгэрцогт	824	1,696,327.60	315	32511.15	10	9352.8				
2	Дэрэн	1083	2,229,517.95	410	42316.1	10	9352.8			1	2417524
3	Говьугтаал	906	1,865,136.90	380	39219.8	10	9352.8				
4	Цагаандэлгэр	533	1,097,260.45	208	21467.68	10	9352.8				
5	Баянжаргалан	866	1,782,790.90	255	26318.55	10	9352.8				
6	Өндөршил	601	1,237,248.65	280	28898.8	10	9352.8				
7	Гурвансайхан	916	1,885,723.40	319	32923.99	10	9352.8				
8	Өлзийт	956	1,968,069.40	461	47579.81	10	9352.8				
9	Хулд	900	1,852,785.00	456	47063.76	10	9352.8				
10	Луус	702	1,445,172.30	294	30343.74	10	9352.8				
11	Дэлгэрхангай	1172	2,412,737.80	456	47063.76	10	9352.8				
12	Сайхановоо	1039	2,138,937.35	380	39219.8	10	9352.8			1	2417524
13	Эрдэнэдалай	2802	5,768,337.30	1262	130251.02	20	18705.6				
14	Адаацаг	1220	2,511,553.00	600	61926	10	9352.8				
15	Сайнцагаан	12729	26,204,555.85	3594	370936.74	50	46764				
		27249	56,096,153.85	9670	998040.7	200	187056	0	0	2	4835048

Д.д	Вакцины нэр	Хамрагдвал зохих хүний тоо															
		Дэлгэрцогт	Дэрэн	Говьугтаал	Цагаандэлгэр	Баянжаргалан	Өндөршил	Гурвансайхан	Өлзийт	Хулд	Луус	Дэлгэрхангай	Сайхановоо	Эрдэнэдалай	Адаацаг	Сайнцагаан	Аймгийн дүн
I	Үндэсний товлोलт вакцин																
1	Сүрьеэ /бцж/	27	42	42	4	14	20	41	51	46	34	44	25	107	52	399	948
2	Халдварт саагийн вакцин	123	177	145	79	80	95	125	189	188	114	199	121	522	199	1478	3834
3	MMR-ийн 3-т вакцин	62	63	70	25	49	58	51	87	95	50	81	71	271	114	677	1824
4	5-т вакцин	96	135	103	75	66	75	84	138	142	80	155	96	415	147	1079	2886
5	Гепатит В-ийн вакцин	27	42	42	4	14	20	41	51	46	34	44	25	107	52	399	948
6	А гепатит вакцин	66	55	73	33	45	56	56	80	100	47	87	74	283	121	655	1831
	Нийт	401	514	475	220	268	324	398	596	617	359	610	412	1705	685	4687	12271

Д.д	Вакцины нэр	Хүлээн авсан вакцин хүн тунгаар															
		Дэлгэрцогт	Дэрэн	Говьугтаал	Цагаандэлгэр	Баянжаргалан	Өндөршил	Гурвансайхан	Өлзийт	Хулд	Луус	Дэлгэрхангай	Сайхановоо	Эрдэнэдалай	Адаацаг	Сайнцагаан	Аймгийн дүн
I	Үндэсний товллолт вакцин																
1	Сүрьеэ /бцж/	160	120	160	20	100	20	160	100	80	100	340	200	820	120	6880	9380
2	Халдварт саагийн вакцин	270	360	280	200	380	230	290	250	300	270	270	250	560	360	1930	6200
3	MMR-ийн 3-т вакцин	185	345	200	155	195	160	245	265	205	135	260	370	555	395	1735	5405
4	5-т вакцин	94	133	103	75	66	75	77	138	140	80	155	95	415	145	1052	2843
5	Гепатит В-ийн вакцин	50	70	90	50	80	60	90	120	80	70	60	50	170	80	490	1610
6	А гепатит вакцин	65	55	73	33	45	56	54	80	95	47	87	74	282	120	642	1808
	Нийт	824	1083	906	533	866	601	916	953	900	702	1172	1039	2802	1220	12729	27246

Д.д	Вакцины нэр	Тарьсан вакцин /хүн тун/															
		Дэлгэрцогт	Дэрэн	Говьугтаал	Цагаандэлгэр	Баянжаргалан	Өндөршил	Гурвансайхан	Өлзийт	Хулд	Луус	Дэлгэрхангай	Сайхановоо	Эрдэнэдалай	Адаацаг	Сайнцагаан	Аймгийн дүн
I	Үндэсний товлонт вакцин																
1	Сүрьеэ /бцж/	27	42	42	4	14	20	41	51	46	34	44	25	107	52	399	948
2	Халдварт саагийн вакцин	121	175	145	79	80	95	118	189	186	114	199	120	522	197	1451	3791
3	MMR-ийн 3-т вакцин	62	63	70	25	49	58	49	87	94	50	81	71	271	113	658	1801
4	5-т вакцин	94	133	103	75	66	75	77	138	140	80	155	95	415	145	1052	2843
5	Гепатит В-ийн вакцин	27	42	42	4	14	20	41	51	46	34	44	25	107	52	399	948
6	А гепатит вакцин	65	55	73	33	45	56	54	80	95	47	87	74	282	120	642	1808
	Нийт	396	510	475	220	268	324	380	596	607	359	610	410	1704	679	4601	12139